

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
“МОНГОЛ СУДЛАЛ”**

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255017>

**Монгол, тува “Илжгэн чихт хаан” үлгэрийн харьцуулал**

М.Ууганбаяр

**Түлхүүр үг:** монгол тува үлгэр, Илжгэн чихт хаан, Веталын хорин таван өгүүллэг, Шидэт хүүрийн үлгэр, Искандерийн эвэр, Мидасын чих

Бид энэ удаа монгол “Илжгэн чихт хаан” үлгэрийн хоёр эхийг тува “Элчиген-Кулак Хаан” гэх үлгэрийн хоёр эхтэй харьцуулахдаа, азербайжаны “Искандерийн эвэр” гэх үлгэртэй ч бас давхар харьцуулав.

**Илжгэн чихт**

Эрт урьдын цагт гэнэ. Илжгэн чихт хаан гэж алдаршсан манжийн нэгэн амбан их говийн дундуур гарсан өвгөн замаар ирж очдог байж гэнэ. Харгис хэрцгий тэр амбаныг харсан хүн бүхний инээд хүрмээр сарьсан багваахайн далавч шиг салбайсан урт хоёр дэлдэн чихтэй юм байжээ. Дээрэлхүү харгис амбан дэвэн дэлхийн амьтнаас дэлдэн чихээ нуух гэж дэндүү их хиээх тул алсын аянд гарахдаа ч албат зарц нараа замын хоёр талаар зэрэгцүүлэн жагсааж зээтүү хүрзээр шороо чулуу цацуулан зэгсэн нууцгай морилдог байсан гэнэ. Ард түмний зүрхийг шаналгасан айхтар сүрхий нэг алба бол үсийг нь авч өгсөн хүнийг, амьтан хүнд дэлдэн чихний нь тухай тараачихаас болгоомжилж амийг нь хороодог байжээ. Ийм учир амбаны зорчдог замын ойр орчмоор айл амьтан нутаглахаа болиход амбан аргаа өөрчилж айлын ганц хүүгээр үсээ авахуулж байхаар болж гэнэ. Нэгэн удаагийн үс авах ээлж ядуу эмгэний ганц хүүд ноогдоход эмгэнэлт энэ албанд тохоогдсон хүн эргэж ирдэггүй болохоор уйтгар гунигт автагдсан ч эрхбиш нэгэн арга сүвэгчлэх хэрэгтэй болжээ. Угаас ядуу зүдүү амьдралд талхигдсан эмгэний ухаан санаанд нэгэн уран арга төрж атга чимх арвайн гурил айл амьтнаас цуглуулж, арав таван ямааныхаа сүүгээр амт оруулан зуурч хэдэн бөөрөнхий үрэл болгож хатааж гэнэ. За миний хүү эр хүнд арван гурван мэх гэж байдаг гэдэг. Юм шүү. Ээж нь ч бас нэг арга нэмье. Амбаны үсийг авч байхдаа энэ үрлийг амандаа хааяа нэгийг хийж, гараасаа алдсан болж ганц хоёрыг амбаны өвөр рүү өнхрүүлээд байгаарай. Амбан чамаас юу гэгчийг идэж, ямар юмаа өвөр рүү өнхрүүлэв гэж асуух байх. Тэгэхэд нь миний хүү ингэж хариу өгөөрэй. Энэ амтганыг эрдэнийн үрэл гэдэг юм, амссан хүний арван цагаан буян дэлгэрдэг юм гэж хэлээрэй. Амбан амсаж үзээд юугаар яаж хийсэн ямар сайхан амттай юм бэ гэх байх. Тэгэхээр нь ээжийн минь сүүгээр зуурч хийсэн энэ үрлийг та бид хоёр хуваагаад идчихлээ шүү дээ гэнэ шүү. Эх хүнээс төрсөн амьтан юм бол эрх биш нэгийг бодох биз гэж захиад хүүгээ амбан руу явуулжээ.

Илжгэн чихтийн үсийг авч байхдаа ядуу хүү, ирэх аюулыг мэдэж байсан ч гэсэн инээд нь хүрээд болохгүй болохоор ээжийнхээ өгсөн үрлээс авч идээд, амбаны өвөр дээр хааяа нэгийг унагаачихаад үсийг нь авч байтал хайрт ээжийн нь урьдчилан хэлсэн ёсоор амбан асуусныг хүү хариулж байжээ. Амбан ноён хэсэг дуугүй сууж байснаа “Аргатай хүү юм даа чи, амийг чинь нэг удаа өршөөе. Нээрээ л эхийнхээ сүүгээр хийсэн чинь үнэн юм бол нэг эхийн хүүхдээс ялгаагүй юм боллоо. Харин чи миний чихний тухай хавь ойрын хэнд ч хэлж болохгүй, элдвийн юм ярьсан байвал энэ муу хар толгой чинь өнхөрнө шүү гэж хэлээд явуулжээ. Хааны үсийг авахаар явсан хүү нь харин амьд эргээд ирснийг хавь ойрынхон нь сонсоод амьд ирсэн шалтгааныг асууж шалгаагаад байхаар нь амбан ноён илжиг шиг чихтэй юм билээ гэж арай ам алдсангүй, ачит буурал ээжийнхээ арга ухааныг ч тоочсонгүй аргалаад өнгөрчээ. Тэглээ ч хааны дэлдэн чихийг хүн амьтанд хэлмээр санагдаад тун болохгүй болохоор нь тэссэнгүй ээжээсээ асуухад “Хэл амаа татаж сур, хэрцгий амбаны хэлсэн үгийг санаж яв. Хэрвээ хүү минь тэсвэр алдвал хэрэг буруудна шүү. Осол аюул багатайгаар нь оготны нүхэнд шивнээд бай” гэж гэнэ. Үүнээс хойш ядуу хүү үлий л дайралдвал “Илжгэн чихт хаан ирж явна шүү” гээд хэлээд явдаг болж гэнэ. Удсан ч үгүй амбан хаан Утай гүмбэнгээ зорин явж байгаад уудам их эзгүй говьд үдлэхээр бууцгаажээ. Амбан ноён амьтан хүнгүй энэ газар алжаасан биеэ амраахаар гадаалж явтал оготны дов бүхэн дээр олон оготно цухалзан “Илжгэн чихт хаан ирж явна” илжгэн чихт хаан ирж явна гээд хашхиралдаж байгааг хаан сонсоод “Оготно хүртэл миний чихийг мэддэг байна шүү. Одоо энэ замаар дахиад явж болохгүй боллоо” гэж шийджээ. Тэр цагаас хойш Хэрмэн замаар илжгэн чихт хаан очихоо больсон юм гэнэ билээ. Муу үг модон улаатай гэдэг энэ байжээ. (Жачин 1988: 153-155)

### Илжгэн чихт хаан

Урьд нэг илжигний чих шиг урт чихтэй хаан байжээ. Хаан албат харьяатнаасаа илжгэн чихээ нуух гэж үсээ авхуулах болгондоо үс авсан хүнийг тэр дор нь цаазалдаг байж л дээ. Тэгсэн тэр нутагт ээжтэйгээ хоёулахнаа суудаг нэг муу ядуу хүүд өнөө хааны үсийг авах ээлж таарч гэнэ. Ээж нь сүүгээ сааж бор бурам бор гурилд багсран бөөрөнхийлж боов хийж өгөөд

-За миний хүү хааны үсийг авч байхдаа л үсий нь нэг хусаад л боовноосоо нэг хазаад л байдаг юм шүү. Тэгэхлээр чинь хаан “Чи юу идээд байна аа” гэвэл наадхаа үзүүлдэг юм шүү. Амсаад үзье гэвэл амсуулчихдаг юм шүү гэж тэгвэл л нэг амь мэнд гарч магадгүй гэж захиад явуулж л дээ. Хүү нь хазаад яршиг удаад байж гэнэ.

Хаан ч тэгтэл

-Үгүй чи хө юу гэгчийг идээд ингэж удаж төдөөд байна аа” л гэж гэнэ шүү.

-Аа би энэнээс л идмээр санагдаад болж өгөхгүй юм гэж ээжийнхээ хийж өгсөн боовыг үзүүлж гэнэ шүү. Хааны сониуч зан нь хөдлөө л

-Алийв хө наадхаас чинь би нэг амсаад үзье гээ л амсаж үзэж гэнээ. Тэгсэнээ

-Үгүй энэ чинь ямар гэгчийн сайхан амттай боов гэж ийм байдаг байнаа л гэж.

Хүү хэлж:

-Аа энэ миний ээж бор бурам бор гурил хоёрыг сүүгээрээ багсарч зуураад хийсэн юмаа л гэж. Тэгсэн чинь хаан нэг сүрхий хараа л

-Хээ, тэгвэл би чамтай нэг эхийн сүү амссан болохоор хороож болохгүй болчихлоо. Ээ дээ чи намайг ийм чихтэй л гэж нэг ч амьтанд ам алдаж болдоггүй юм шүү. Нэг л хүнд хэлсэн байх юм бол толгойг чинь авна шүү л гэж.

Хүү ч

-За за л биз.

Хаан бас хэлж:

-Чи хө ухаантай сэргэлэн хүний үр байна, надад энэ чихээ нуух нэг сайн арга хэлж өгөөч л гэж. Хүү хэлж:

-Аа тэр амархан, та энэ ертөнцийн хагасыг захирсан их хаан болохлоор том жижиг хаад цугаар ийм малгай өмсчих. Тэхээр бусдаас огт ялгарах юм байхгүй болно гэж хэлдэг байж. Ядуу хүн амьд мэнд гарч гэртээ ирсэн боловч хааны нууцыг алдчих вий гэж биеэ чагнасаар үс зүс нь буурч бүүр хүний нүднээс гарч гэнэ. Аргаа бараад нэг мэргэн хүн дээр очоод асуусан чинь

-Ээ хүү минь, чи нэг л нууц юм гадагшаа алдчих вий” гэж дотроо бугшуулсаар яваад ийм болтлоо хатчихсан хүн байна” гэж.

-Одоо тэгээд би яадаг шүү юм билээ гэсэн

-Хүү минь чи тэр үгээ эзгүй хээр газар буруу харсан нүх рүү сэтгэлээ амартал хашхирч хэлбэл зүгээр болно гэж. Хүү мэргэн хүний үгэнд орж эзгүй хээр газар ирээд буруу харсан нүхэнд “Манай хаан илжгэн чихтэй, манай хаан илжгэн чихтэй” гээд сэтгэлээ тэнийсхийтэл өчнөөн төчнөөн хашхирч гэнээ. Тэгсэн чинь өвч ногоо хүртэл “Манай хаан илжгэн чихтэй” гэж ганхаад, ус хүртэл “Манай хаан илжгэн чихтэй” гэж урсаад, салхи хүртэл “Манай хаан илжгэн чихтэй” гэж салхилдаг болсон гэнээ. Хаан тэр олон юмны алий нь цаазаар ав бархав дээ. Тэгээд тэр хүүгийн зөвлөснөөр чихэндээ таарсан малгай хийж өмсөөд бусад олон хаадыг ийм малгайтай бол гэж зарлиг буулгажээ. Тэр цагаас хойш хааны титэм гээч гарсан юм гэнэ. Нөгөө хүү ч хэлж болдоггүй үгээ хэлж аваад сэтгэлийн зовлонгүй болж ядуу ч гэсэн амар сайхандаа жаргажээ. (Дулам 2018:547)

### Элчиген-Кулак хаан

Эртенгиниң эртезинде, бурунгуниң мурнунда, буга-деге мыйызы буступ дүжүп турар шагда чүвең иргин. Үш ак чаанның, эди эктин ашкан, малы бажын ашкан Элчиген-Кулак деп ирик бай хаан чурттап чораан. Ол хаанның албатыларының аразынга кырган иелиг ийи кайгал оол чурттап чораан. Бир-ле катап иешкилерниң чеми үзүлгеш, улуг оглу чоруткаш, хаанның үш чаанының бирээзин оорлап алган. Даартазында хаан чааннарның бирээзин чоктап каапкаш, бодунуң шивишкинин кончуг яды-түреңги кижиг кылгаш:

-Өглер кезип, эът-чагдан диле. Бир эвес чаг берген өг болза, эжииниң аксынга демдектеп кааш, меңээ чугаалаар сен – деп дужаагаш, чорудупкан.

Даартазында ол шивишкин өглер кезип чорааш, ол иешкилерниң өөнгө кирип келгеш, эът-чаг диленген. Оолдарның иези кээргээш, демги чаанының эдинден элээн эът-чаг берген. Шивишкин үнүп бар чорааш, эжик аксынга «Ак чаанның эдин бо өгден алдым» деп бижип кааштың, чоруй барган.

Оглу ажылдап чорааш, чанып келгеш, көөрге, эжик аксында бижик бижип каан болган. Номчуп-номчуп, иезинге келгеш, айтырган:

-Маңаа кижиг келди бе, авай?

-Ийе, оглум, маңаа диленчи кижиг келгеш, эът-чаг айтырарга, хөөкүйнү кээргээш, бичии эът-чаг бердим.

-Каям, авай, бичии эът-чагдан эккелем – дээш, иезинге чаг алдырып алгаш, ол коданның өглериниң эжииниң шуптузунга “Ак чаанның эдин бо өгден алдым” деп бижип каан.

Даартазында демги шивишкин хаанын эдерттип алгаш, демги эът-чаг алган өөнгө чедире берген. Эжик аксында бижикти номчааш, канчангаш-ла өске өглер эжиктерин көрүптөргө, шуптузунда ынчаар бижип каан болган.

Хаан аайын тыппайн, чанып келгеш, бодунуң өөнүң эжиин көөргө, база ынчаар бижип каан болган.

Хаан оорну тып чадааш, хамык улузун арагаладып эгелээн.

-Бир эвес ак чаанны оорлаан кижини болза, бир караан көрүп, бир караан базып алгаш, удуур чүве-деп-тир.

Канчангаш-ла демги оор оол оттуп кээрге, бир караан базып алгаш, удуп чыткан бооп-тур. Оол туп-тура халааш, хамык улустуң караан ажыдып эгелээн.

Хаан чедип келгеш, көөргө, хамык-ара-албатызы шуптузу бир караан базып, бир караан көрүп алгаш удуп чыдып турлар.

-Ам канчаар, ак чаанны оорлаан кижини тыбылбайн барган-дыр – дээш, хаан олчаан дүвүрей берген.

Ол хаанның кулаа элчиген кулаа-биле дөмей узун болгаш, бажының дүгүн чүлээн кижини-ле бажын кезип өлүрер хаан чүвең иргин.

Шыяан ам, бир-ле катап хаанның бажының дүгүн чүлүүр өйү чедип келген. Ээлчег ак чаанны оорлаан оолдуң дунмазынга келген. Оолдуң иези муңгарап-деңгереп, боданып тургаш, оглунга эмииниң сүдү-биле далганны үш хонук иштинде холуп тургаш, тудуп бергеш, чорудуп тура:

-Хаанның бажын чүлүп тура, ”Бичии дыштанып алыин” дээш, көргүспейн, чиир сен, оглум. Оон бир чүве болур ийик – деп-тир эвеспе.

Оол баргаш, хаанның бажын орту киир чүлээш:

-Адыр, хаан, мен бичии дыштанып алыин-дээш, хойнундан борбак чүве уштуп эккелгеш, хаанга-даа көргүспейн, чип турар болган.

Хаан олургаш:

-Каям, чип турар чүвең, оол. Мен база чип көрейин-деп-тир.

Оол ынавайн, чааскаан чип-ле орар болган-дыр эвеспе. Пат боорда хаан ээрежип оргаш, ап алгаш, чип көөргө, муңгаранчыг амданныг бооп тур. Хаан олургаш:

-Бо чүү мындыг кончуг амданныг чүвеңил, оол? – деп тур.

Оол олургаш:

-Бо болза мээң төрөөн авамның төрөөн эмииниң сүдү-биле катай тудуп каан далган-дыр-деп тур эвеспе.

Ынча дээрге, хаан чугаалап тур эвеспе.

-Ындыг болза бис ийилээн иеден төрөө-ле ийи алышкы болуулу-деп хөөреп-даа орган хаан чүвең иргин.

Ону дыңнааш, оол база чугаалап тур эвеспе.

-Мээң акым ак чаанның оору чүве. Ынчаарга ону чугаалаар болзуңза, сээң бажыңны мен база кезер мен-деп орган эр чүвең иргин.

Элээн үр үе эрткенде, база-ла хаанның бажының дүгүн чүлүүр үе келген. Барып-барып хүнүн манаан, хүүрөөн даянган кырган кадайның чаңгыс оглунга таварышкан. Оолдуң иези демги оор оолдуң иезинге чеде бергеш, айтырып тур.

-Сен оглуңнуң тынын канчаар камгалап алдың? – деп айтырарга, оолдуң иези «Мындыг-мындыг болган чүве» деп, болган таварылганы шуптузун чугаалап берген.

Кырган кадай чүнү-даа бодап чадап кааш, оглу-биле байырлашкаш, чорудупкан. Канчангаш-ла көөргө, хаанның өөнүң эжиинде күскелер тараа чыып чип чыдып тур. Кырган кадай орта сагыш алынгаш:

-Канчап букшуй берген чурт боор, күске-күжүген “Элчиген-Шивегетей хаан”, “Элчиген-Шивегетей хаан” деп алгыржып турар?-дээш, шыкпыыр тудуп алгаш, ол күскелерни ойладып туруп тур эвеспе.

Хаан ону дыңнай кааш:

-Улус шупту билир чүвени хей-ле улус өлүргөш канчаар мен! -дээш, бөрт чок үнө халып кээрге, узун кулактары анаа кижиге кулаа болу берип-тир эвеспе.

Ол ийи кадайның оолдары-биле ол хаан иеден төрээ-ле үш алышкы болуп, оюн оя, чирин чире чурттай чоруй барып-тыр оо. (ТИПСЭИА: 9, 39: 8-14)

### Элчиген-Кулак хаан

Өглөөний эртэд урьдын урьд бух тэхийн эвэр мултран унаж байх цагт юм гэнэ. Гурван цагаан заантай, эд нь мөрийг нь давсан, мал нь толгойг нь давсан Элчиген-Кулак гэх хөнөөлт муу баян амьдарч байжээ. Тэр хааны албат дунд хөгшин өтөл ээжтэй хоёр гайхал хүү амьдарч байжээ.

Нэг удаа эх хүүхдүүдийн хоол хүнс дуусч том хүү яваад хааны гурван зааны нэгийг нь хулгайлан авчээ. Маргааш нь хаан нэг заан алга болсныг мэдчихээд, шивэгчнээ машид ядуу зүдүү хүн болгож хувилгаад

-Гэрүүдээр хэсч мах өөх гуй. Хэрвээ өөх өгөх айл байвал хаалганы аманд нь тэмдэглэж орхиод надад хэл гэж тушаагаад явуулжээ.

Маргааш нь тэр шивэгчин гэрүүд хэсч яваад тэр эх хүүхдүүдийн гэрт очоод мах өөх гуйжээ. Хөвгүүдийн ээж хараад зааныхаа махаас нэлээд мах өөх өгчээ.

Шивэгчин гарч яваад хаалгын аманд “Цагаан заанын махыг энэ айлаас авсан” гэж бичиж орхиод явжээ. Хүү ажил хийж яваад буцаж ирээд харгал, хаалганых нь аманд бичиг бичиж орхисон байжээ. Уншиж уншиж ээждээ ирээд асуужээ

-Манайд хүн ирсэн юм уу ээжээ?

-Тийм хүү минь манайд гулга гуйдаг хүн ирээд мах өөх асуухаар нь хөөрхийг өрөвдөөд баахан мах өөх өгсөн

-За, ээжээ, мах өөхөөс жаахныг авчир гээд ээжээрээ мах авахуулж аваад тэр хот айлын бүх гэрийн үүдэнд “Цагаан зааны махыг энэ айлаас авсан юм” гэж бичээд орхижээ.

Хаан учрыг нь ололгүй буцаж ирээд өөрийнхөө гэрийн үүдийг харахад үүдэнд нь бас л тийм бичиг бичиж орхисон байжээ.

Хаан хулгайчийг олж чадсангүй хамаг улсыг архиар дайж эхэлжээ.

-Хэрвээ цагаан зааныг хулгалсан хүн байвал нэг нүд нь хараастай нөгөө нүд нь аниастай унтанх юм гэжээ.

Гэнэт өнөөх хулгайч хүү сэрээд харгал нэг нүд нь аниастай унтаж байжээ. Хүү гэнэт босч хамаг хүмүүсийн нэг нүдийг нь аньсан нүдийг нь нээчихжээ. Хаан хүрч ирээд харгал, хамаг ар албатууд нь бүгдээрээ нэг нүд нь аниастай нөгөө нүд нь хараастай унтаж байж гэнэ.

-Одоо хэрхэх вэ, цагаан зааныг хулгайлсан хүнийг олохгүй нь гэж ихэд санаа зовнижээ.

Тэр хааны чих нь илжигний чих шиг урт бөгөөд үсийг нь тайрсан хүний толгойг нь авч үхүүлдэг хаан юм сан жээ.

За тэгээд, нэг удаа хааны үсийг авах цаг болжээ. Энэ удаа цагаан зааны хулгайлсан хүүгийн дүүгийн ээлж болжээ. Хүүгийн ээж гуниглан энэлж бодолд автан хүүдээ хөхнийхөө сүүг талхтай гурав хоног холиод өгч явуулахдаа

-Хааны үсийг тайрч байхдаа “Жаахан амраад авъя” гээд үзүүлэхгүйгээр үүнийг

ид миний хүү . Тэгээд нэг юм болох биз гэсэн аж.

Хүү очоод хааны толгойг дунд хүртэл тайраад

-Одоохон хаан минь би хэсэгхэн амраад авъя гээд өврөөсөө бөөрөнхий юм гаргаад хаанд үзүүлэлгүй идэж байжээ. Хаан:

-Хүү минь идэж байгаа юмнаасаа өгөөч би ч бас идэж үзье гэжээ.

Хүү тоолгүй, ганцаараа идэж байв гэнэ. Хаан арай гэж гуйж аваад идэж үзэхэд ихэд амттай байжээ. Хаан:

-Энэ ямар сайхан амттай юм бэ? хүү минь гэж асуужээ. Хүү

-Энэ миний төрсөн эхийн хөхний сүүгээр зуурч хийсэн гурил гэж гэнэ. Тэгээд хаан хэлжээ.

-Тийм бол бид хоёул ээжээс төрсөн ах дүү хоёр болоё гэж хаан ярьжээ. Түүнийг сонсоод хүү бас ярьжээ.

-Миний ах чиний цагаан зааныг хулгайлсан юм. Тэгэхээр түүнийг ярьвал чи түүний толгойг бас авах уу гэж хэлсэн юм гэнэ.

Нэлээд хугацаа өнгөрсний хойно бас хааны толгойн үсийг авах цаг иржээ. Өдрөө хүлээж, хүрээ тулсан хөгшин эмгэний ганц хүүд ээлж тохиов. Хүүгийн ээж нөгөө хулгайч хүүгийн ээжид хүрч очоод асуужээ.

-Чи хүүгийнхээ амийг яаж аварч үлдсэн бэ? гэж асуухад хүүгийн ээж “Ийм ийм юм болсон” гэж тохиолдсон болгоныг бүгдийг нь ярьжээ.

Хөгшин эмгэн юу ч бодох сөхөөгүй хүүгээ үдэж өгч явуулжээ. Тэрээр гэнэт хартал хааны гэрийн үүдэнд хулганууд тариа хурааж идэж байжээ. Хөгшин эмгэн бодож байснаа:

Ямар буг чөтгөрийн улс орон гээч вэ хулгана, гичгэнэ хүртэл “Элчиген Шивегетей хаан”, “Элчиген Шивегетей хаан” гэж хашгирч байна гэж үглэн саваа аваад хулгануудыг хөөж эхлэв гэнэ.

Хаан түүнийг сонсоод

-Бүх хүний мэдэх юмаас болж, олон хүнийг үхүүлж юугаа хийнэ! гээд малгайгүй гарч иртэл урт чих нь ердийн хүний чих болж хувирав гэнэ.

Тэр хоёр эмгэний хөвүүд хийгээд хаан төрсөн гурван ах дүүс болж, судаг нэвтэлж, хотгор хонхойлж жарган суув гэнээ.

### Элчиген-Кулак хаан

Элчиген-Кулак деп хаан чуртгап туруп тур оо. Ол Элчиген-Кулак хаан кулаан чажыар хаан-дыр. Бажының дүгүн алзыр санында-ла кижиниң чаңгыс оглу, хатөрел чок эр чаңгыс оол кижини кыйгыртыр. Оон ол кижини улуска чарлавазын дээш, өлүрүп кааптар мындыг турган-дыр ийин.

Бир херээжен кижиниң чаңгыс оглун кыйгырткаш, бажының дүгүн алзыр деп барган. Оглу тургаш, авазынга:

-Мени хаан “Бажым дүгүн кыргып бер” деп кыйгырткан-дыр-дээрге, авазы оглун өлүртпес дээш:

-Мындыг арга айтып берейн-дээш, бодунуң эмииниң сүдүн саггаш, чигир-үзүм-биле холуй туткаш, далган хаарып, хойлаткаш, чорудупкан-дыр.

-Сен хаанның бажын дүгүн ап тургаш, бо хаарган далганны хаанның эдээнче оскунган кижини болуп алгаш, дүжүрер сен-дээн.

Оглу-даа ол хаанның бажын дүгүн таарып тургаш, ол далганын хаанның эдээнче далганын ышкынып дүжүрген-дир ийин.

Хаан ол далганны чип көөрге, кончуг амданны боова болган. Айтырган-дыр.

-Кандыг кончуг амданныг аьш-чем чүвел? – дээн.

-Мээң авам быжырган – деп тур.

-Чүнүн-биле быжырган чүвел? – дээрге:

-Эмииниң сүдүн саггаш, ары чигири холуп тургаш, быжырган чем-дир ийин – деп чугаалаан.

Ол хаан угаанныг кижиге чүү боор, «Чаа, ам ындыг болза бажымның дүгүн алдыргаш, бо кижини өлүрүп болбас. Авазының аа сүдүн үлежип ишкен кижиге мээң дунмам болур, аравыста ха-төрөл апардывыс. Бо кижини өлүрүп болбас» деп бодааш, ол оолга чагып-чагып чугаалаан-дыр.

-Чүгле сен кымга-даа мээң кулаамны чугаалап болбас. Чугаалаксаар болзунза, дедир көрүнгөн аастыг үңгүрге баргаш, чугаалаар сен – дээн.

Та чаңгыс хонган чүве, оол-даа хаанның кулаан көргөн кижиге чүү боор, улуска чугаалаксааш, шыданмас. Оон дедир аастыг тарбаган үңгүрүнге, өрге-күске үңгүрүнге баргаш, ынаар:

-Кулактыг, кулактыг хаан. Элчиген кулактыг хаан! деп сымыранган-дыр.

Бир эртен хаан-даа чиигенип олурда, күскелер-даа “Кулактыг, кулактыг хаан. Элчиген кулактыг хаан!”, тарбаганнар-даа “Кулактыг, кулактыг хаан. Элчиген кулактыг хаан!” деп алгырып-ла турар мындыг болган-дыр.

Хаан-даа бодангаш:

-Оон ам канчаар, мону демги оол чугаалаан-дыр. Кижиге хамаанчок, делегейниң аң-меңи-даа билер чүвени чажыргаш канчаар мен – дээш, ол кулаан чажырып турган аржыылын алгаш, өрттедипкен чүве-дир.

Ол хевээр кулаан чажырбастай берген чүве-дир. (Мигир-Мижит хаан 2020: 157)

### Элчиген-Кулак хаан

Элчиген-Кулак гэх хаан амьдарч байжээ. Тэр Элчиген-Кулак хаан чихээ нуудаг байжээ. Толгойнхоо үсийг авахуулах бүртээ хүний ганц хүүхэд ах дүүгүй ганц хүүхдийг дууддаг байжээ. Тэгээд тэр хүнээ өөр хүмүүст зарлахгүй байгаасай гэж хөнөөдөг байжээ.

Нэг эмэгтэйн ганц хүүг нь дуудаж толгойн үсээ авахуульга гэжээ. Хүү ээждээ

-Намайг хаан “Миний толгойн үсийг тайраад өг” гэж дууджээ- гэхэд, ээж нь хүүгээ үхүүлэхгүй гэж,

-Ийм арга чамд зааж өгье- гээд өөрийн хөхнийхөө сүүг саагаад, чихэр үзэмтэй холиод талхаа хайрч хүүгийнхээ өвөрт нь хийгээд явуулжээ.

Чи хааны толгойн үсийг авч байхдаа энэ хайрсан талхыг хааны хормойд алдаад унагасан мэтээр унагаачих гэжээ.

Хүү тэр хааны толгойны үсийг тайрч байхдаа тэр талхыг хааны хормойд мэдэхгүй дүр эсгээд унагачихсан юм гэнэ.

Хаан тэр талхыг идэж үзвэл маш амттай боов байжээ. Асуужээ.

-Ямар амттай хоол бэ? гэжээ.

-Миний ээж чанасан- гэжээ.

-Юугаар чанасан бэ?- гэхэд

-Хөхнийхөө сүүг саагаад чихэр холиод чанасан хоол гэж хариулжээ. .

Тэр хаан ухаантай хүн болохоор За одоо ийм бол толгойныхоо үсийг авахуулаад энэ хүнийг үхүүлж болохгүй ээжийнх нь сүүг надтай хуваан уудаг хүн миний дүү болно, бид төрөл садан улс. Энэ хүнийг үхүүлж болохгүй гэж бодоод тэр хүүд захиж захиж ярьжээ.

-Ердөө хэнд ч миний чихний талаар ярьж болохгүй. Чи яримаар байвал уруугаа харсан амсартай нүх рүү очоод ярь- гэжээ.

Нэг хонов уу үгүй юу хүү хааны илжгэн чихийг харсан юм болохоор хүмүүст хэлэхийг хүсэн тэсгэл алдах болжээ. Тэгээд уруугаа харсан амсартай тарваганы нүх, зурам, хулганы нүхэнд очиж

-Чихт хаан чихт хаан илжгэн чихт хаан !-гэж шивнэв гэнэ.

Нэг өглөө хаан бие хөнгөрч суутал хулганууд “Чихт хаан, чихт хаан. Илжгэн чихт хаан ” гэж тарвагас “Чихт хаан чихт хаан. Илжгэн чихт хаан” гэж хашгиран гүйлджээ.

Хаан ч бодоод:

-Юу ч болтугай, үүнийг хүү хэлчихэж. Хүмүүс хамаагүй газар дэлхийн ан амьтас ч мэдэх зүйлийг би яахин нууна гээд чихээ далдалсан алчуураа аваад шатаасан юм гэнэ. Түүнээс хойш хаан чихээ нуухаа больсон юм гэнэ.

Б.Я.Владимирцов түүх нийгмийн янз бүрийн нөхцөл байдлаас болоод энэтхэгийн ном бичгийн үлгэрийн цоморлигууд эрт дээр цагаас эхлэн Энэтхэг орны хил хязгаарыг давж дорно өрнийн олон оронд дэлгэрсэн бөгөөд ялангуяа монголын ертөнцөд Энэтхэгийн “Веталын хорин таван өгүүллэг” гэх үлгэрийн чуулбар шидэт хүүрийн үлгэр нэрээр ихэд алдаршсан тухай бичсэн ба Б. Я. Владимирцов, Монгол “Шидэт хүүрийн үлгэр” Сиддит Кюр-ийг Энэтхэгийн “Веталын хорин таван өгүүллэг”-тэй ойр дөт төрөл гарлын холбоотой (Владимирцов 1958: 10) гэжээ. Ц.Дамдинсүрэн “Шидэт хүүрийн үлгэр”-ийг угаас Энэтхэг гаралтай зохиол мөн гээд энэхүү үлгэр энэтхэгийн санскрит ба бусад хэлээр “Веталын хорин таван үлгэр” нэртэй байдаг гэв. Ц.Дамдинсүрэн энэтхэгийн ямар нэгээс төвд хэлэнд орчуулсан бололтой “Шидэт хүүрийн үлгэр” Монголд хэдийнээ нэвтэрч, монголын ард түмэнд түгээмэл дэлгэрч зарим бүлэг нь ардын аман зохиол болон хувирсан байна (Дамдинсүрэн 2017: 7) гэв. Мөн Ц.Дамдинсүрэн, С.Д.Серебряный нар монголчууд “Шидэт хүүрийн үлгэр”-ийн хажилгат чуулбартаа энэтхэгийн “Веталын хорин таван өгүүллэг”-ийн зөвхөн хажилгын ерөнхий бүтцийг нь /общая структура оформления/ аваад энэхүү хажилгаа өөрчилж өөр өгүүлэмжүүдээр нөхсөн гэжээ. (Дамдинсүрэн 1987 : 33) Т.Бенфей гэгч эрдэмтэн монголын “Шидэт хүүрийн үлгэр”-ийг энэтхэгийн “Веталын хорин таван өгүүллэг”-ийн монголжсон төгөлдөржил гэж үзсэнийг Ц.Дамдинсүрэн, С.Д.Серебряный нар “Шидэт хүүрийн үлгэр”-ийг эхлээд энэтхэгийн зохиолуудаас төвөд хэл рүү дараа нь төвөд хэлнээс монгол хэлнээ энгийн зээлсэн орчуулсан төдий бус энд илүү нарийн нийлмэл хувирал өөрчлөл хэрэгжсэн гэжээ (Дамдинсүрэн 1987: 32-33) Б.Я.Владимирцов “Монголын уран зохиол” гэх өгүүлэлдээ “Монголын “Сидди-кюр” ч мөн төвдийн ардын уран зохиолоос зээлэгдсэн ба төвөдийн аман уран зохиолын гүнд энэтхэгийн цоморлиг бүрэн өөрчлөгдөн зохиогдож, огт өөр хүрээ үүсчээ (Владимирцов 2003: 71) гэсэн бол Ц.Дамдинсүрэн “Шидэт хүүр болбоос монголын ард түмний олон зуун жилээр сонирхон уншсаар ирсэн жинхэнэ ардын дур сонирхлыг татсан номын нэг болмуй. Шидэт хүүрийн олонх бүлгүүд ардын дунд гүн нэвтэрч аман зохиол болж хувирсан ба бас ч монгол аман зохиолын зарим сэдэв “Шидэт хүүрийн үлгэр”-г нэвтрэн орсон баймуй. Монгол “”Шидэт хүүрийн үлгэр болбоос монголын ард түмний уран билэгтний бүтээл мөн гэжээ. (Дамдинсүрэн 2017: 483)

Бид Ц.Дамдинсүрэнгийн хэвлүүлсэн “Төвөд, Монгол шидэт хүүрийн үлгэр” гэх бүтээлийн Шидэт хүүрийн үлгэр гэх хэсгээс Илжгэн чихт хааны хорин хоёрдугаар бүлэг буюу Шидэт хүүрийн хуулиас Илжгэн чихт хааны хорин хоёрдугаар бүлэг гэх эхийг энд мөн харуулж байна. (Дамдинсүрэн 2017: 57-59)

Илжгэн чихт хааны хорин хоёрдугаар бүлэг буюу Шидэт хүүрийн хуулиас Илжгэн чихт хааны хорин хоёрдугаар бүлэг

Тэндээс одохуй ёс урьдах мэт үйлдэж бүрүүн, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд, бас хүүр энэ үлгэрийг өгүүлрүүн:

“Бас эрт урьд цагт энэтхэгийн дорно зүгийн хар хятадын Тайван хаанд нэгэн хөвгүүн бүлгээ. Тэр хөвгүүн нь хаан оронд суугаад, хүнд биеэ нэгээхэн бээр үл үзүүлэгч бүлгээ. Өдөр бүр улсаас нэг сайхан хөвгүүнийг авч одоод, үсээ шүүрдүүлээд алагч бүлгээ. Олон жил болтол тийн албаас нэгэн өдрийн учирт нэгэн эмгэнд ганц хөвгүүн ажгуу. Хааны үсийг шүүрдэх хувь нь тэр хөвгүүнд хүрвээс, эх нь “Хөвгүүндээ алму” хэмээж гэмшиглэнт болоод эх нь хөвгүүндээ шинэ хувцсыг өмсгөөд, өөрийн хөхний сүүг гурилд зуураад моголцоглож өвөрт нь дүрж өгөөд, “Хааны үсийг шүүрдэхдээ үүнийг бага бага идэж шүүрд. Чамайг алахгүй ч буй за” хэмээвээс, хөвгүүн нь хааны дэргэд очоод, алтан хатгуураар үсийг самлахуйд хааны чих нь илжигний чихэнд адил бүлгээ. Түүнийгээ хүнд өгүүлэх хэмээгээд алахын учир тэр бүлгээ. Хааны үсийг шүүрдэхдээ гурилаа идэж суухуйд хаан асууруун:

-Чиний энэ идэгч идээ юу вэ хэмээвээс,

-Тутарганы гурил бүлгээ хэмээн өчвөөс, хаан нь

-Надад өгөгдөх хэмээв. Төдий нэгэн хэсэг гурилыг хаанд өргөвөөс, хаан зооглоод,

-Үнэр амт маш сайхан, энэ юун хольсон буй хэмээвээс хөвгүүн өчрүүн:

-Эх минь өөрийн сүүндээ зуурч өгсөн бүлгээ хэмээн өчвөөс хаан нь ийн сэтгэрүүн: “Үүнийг алж үл болму. Энэ бид хоёр нэг эхийн сүү уусан бөгөөтөл төрлөө алах ёсон хаана болох би чамайг бүү алуугай. Намайг илжгэн чихт хэмээн бус хүнд өгүүлэх үү хэмээвээс “Аяа, хаан, би хэнд бээр үл өгүүлмүй. Тийм бөгөөс эхдээ бүү өгүүл. Хэрвээ хүнд хэлсэн өгүүлбээс би чамайг алах буй” хэмээн захирвай. Бус хэн бээр мэдсэнгүй бүлгээ. Тэр хөвгүүн гэртээ харьж одвой. Түүний хойд шүүрдэгч хөвгүүдийг урьд ёсоор албай. Бүгдээр “Эмгэний хөвгүүн жаргалт бүлгээ” хэмээн гайхалдвай. Хамаг бүгдээр түүнээс “хэр мэт бүлгээ” хэмээн асууваас, эх тэргүүлэн бүгдэд юун бээр эсхүү өгүүлээд, хааны чих нь бусдаас үлэмж болсныг бус хэнд эсхүү өгүүлээд дотроо санасны тул тэр хөвгүүн их хатуу өвчин хүртэж эм хийгээд дом тэргүүтэн хэрэг зэрэг юуныг бээр үйлдвээс тус эс болжээ. Төдий үхэхэд хүрвээс нэгэн отчийг залж ирээд судсаа бариулвай. Эмч нь өгүүлрүүн: “Чамд сэтгэлийн өвчнөөс бус өвчингүй” хэмээгээд “Энэ өвчинд эм тус үл болму. Сэтгэлд санаснаа аманд гаргаж хэлбээс эдгэх бүлгээ” хэмээвээс хамаг бүгдээр нэгдэж

-Үг буй бөгөөс эдүгээ өгүүл. Үхэхдээ эс өгүүлснийг хойно хэзээ өгүүлэх, тэр хөвгүүн

-Үгүй хэмээн эс хэлээд нэгэн учирт эх нь шамдаж асууваас, эхдээ нэгэн өгүүлэх үг буй бүлгээ. Хэрвээ өгүүлвээс хааны засаг болму. Эх нь тийм бөгөөс хүнгүй аглагт одоод, газар чулуу хийгээд модны нэгэнд өгүүлбээс эдгэмүй. Хөвгүүн нууж одоод нэгэн оготны нүхэнд амаа тулгаж, “Манай хаан илжгэн чихтэй бүлгээ” хэмээн олонтаа давтаж өгүүлбээс тэндээс тэргүүлж тэр хөвгүүн эдгэвэй. Тэр нүхэн дэх оготно түүний үгийг сонсоод оготноо дуун гарваас салхи лугаа нийлж хааны чихэнд сонсвой. Төдий “төдий энэ үгийг тэр хөвгүүн хэлсэн ажгуу” хэмээн элч илгээж тэр хөвгүүнийг хааны дэргэд авч ирээд хаан зарлиг болруун:

-Би чамайг хүнд бүү өгүүл хэмээж захирсан бүлгээ. Өдгөө чиний заяа хүрсний тул, тийм үг өгүүлэв үү хэмээн асууваас, хөвгүүн өчрүүн:

-Би өөрөө нэгээхэн бээр хэрийн төдий өгүүлсэнгүй бүлгээ хэмээвээс хаан

-Нэгэн хүнд хэлсэн ажгуу, чи. Тэр үгс чинь над сонстов. Эс хэлвээс над хэрхэж сонстох хэмээвээс, хөвгүүн

-Гэртээ хариад надад хатуу өвчин хүртэж, ураг элгэн бүгдээр юун буй хэмээн асууваас би эс өгүүлсэн бүлгээ. Төдий үхэхэд ойртоод нэгэн отчийг залж судсаа бариулбаас отчийн өгүүлсэн эх юүгээн өгүүлснийг дэлгэрэнгүй өгүүлээд оготнын нүхэнд хэлснээс бус хүнд хэлсэнгүй бүлгээ. Муу үгийг салхи өгүүлснээс бус хэн өгүүлэх. Төдий хаан нь

-Би чих болов хий лүгээ хольцсоныг сонссон бүлгээ хэмээгээд,

-Үүнийг алж юу хийх. Эдүгээ энэ миний чихэнд аргалах арга чамд буюу хэмээвээс, хөвгүүн

-Аяа, их хаан миний үгэнд орох бөгөөс надад нэгэн арга буй бүлгээ. Хаан нь

-Хөвгүүн чи тэр аргаа надад өгүүл. би сонссугай. Хөвгүүн өчрүүн:

-Аяа, их хаан тэргүүндээ нэгэн малгайг хийгдэх түүний хоёр этгээд чихээ далдлах эвэртэй малгай хийж өмсөөд дэргэдэх нөхдөд бас тэр ёсоор өмсгөж хурваас зохимуй” хэмээн өчвөөс тэр үгийг зөвшөөж, малгай хийж нэгэн сайн өдөр өмсөөд, хаан ширээн дээр сууж, харцас бүгд чуулаад тэр малгайг бүгдээр гайхалдаж магтаад, бүгдэд алдаршвай. Төдий бүгдээр хааны чих илжигний адилыг эс мэдээд чимэг болгож “Эвэрт малгай” хэмээн алдаршжээ. Эдүгээ манагар Дайван хааны дэргэдэх яамтанд тийм малгай буй бүлгээ. Эмгэний хөвгүүн засгийг баригч түшмэл болоод, хүн алах юугаан тэндээс байвай. Төдий хамаг их улс амууж жаргалаа” хэмээсэнд Сайн амгалант хаан “Танц хааны чихний тул тийм олон хүний аминд орсон эмгэний хөвгүүн сайн билигт бол” хэмээвээс “Заяагаа барсан хааны амнаас дуу гарвай. Сарвад үл сууму би” хэмээж огторгуйгаар нисэн одвой.

Шидэт хүүрийн хуулиас илжгэн чихт хааны хорин хоёрдугаар бүлэг (Дамдинсүрэн 2017: 57-59)

Монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэрийн дөрвөн эхийг төвгд, монгол “Шидэт хүүрийн үлгэр”-тэй харьцуулж үзэхэд, монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэрүүд энэхүү “Шидэт хүүрийн үлгэр” гэх хажилгат туужийн айн (жанр обрамленной повести) хүүрнэл цоморлиг монгол тува аман зохиолд үлгэр болон дэлгэрсний баримт болж буй. А. С. Донгак тува аман зохиолд монголын уран зохиолын хажилгат туужийн айн дурсгалуудаас зээлэгдсэн өгүүлэмж өргөн тархсан гэв (Донгак 2004: 4) Тува аман зохиолд Шидэт хүүрийн үлгэрийн өгүүлэмж бүхий олон аман үлгэр бий. Үүнийг нэг нь бидний авч үзсэн “Элчиген-Кулак хаан” буюу “Илжгэн чих хаан” гэх үлгэр билээ.

Монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэрийг азербайжаны “Искандерийн эвэр” гэх үлгэртэй харьцуулж болно.

Азербайжаны энэ үлгэрт Македонийн Александр буюу Искандер падишах урт чихтэй гэж гардгаараа монгол, тува “Илжгэн чихт хаан” үлгэрээс ялгаатай байна.

### **Isgəndərin buynuzu**

Deyir bir dənə paccah var imiş, o paccahın da buynuzu var imiş. Amma bunun sifətini heş kəs görmür. Ancax onun yanına girib çıxan qulluxçusu görübdü. Bir dənə də dəllək var imiş. O görürmüş, bir də özünün yoldaşı, yanına girib çıxannar. Deyibmiş ki, bircə kəlmə ağzınızdan eşitsəm onnan sonra boynuzu vurajam. Heylə də eliyirmiş ha. Günnərin bir günündə bunun üzünü qırخان dəllək əjalı yetib ölür. Onnan sonrasına gedillər neçə dənə dəlləh gətirirsə, üzünü qırخان kimi boynunu vurdurur da ki, mənim sirrimi çıxarmasın. Bilib ki, nətər olsa, danışajax. Axırı dünyada dəlləh qalmıyıbdı. Bircə

dənə dəlləh galıbmış. Diyib ki, bəs nağarax, nətər eliyək. Bu dəlləyi gətirsəh, öldürsən, daa dəlləh yoxdu. Deyir: “Gətirginən, ona bir tapşırıx verərəm”. Deməli, dəllək də çoban imiş. Dağda qoyun güdürmüş. Gətiriblər bu dəlləyi, başdıyıbdı üzünü qırxiybdı. Qorxub eləmiyibdi. Deyibdi ki, səni yeri qazıb yerin altına girsən boynunu vuracayıq əyəmnəri bu sirri bir kəsə desən. Paccah buna tapşırıbdı. Deyibki, yaxşı, danışmaram. Gəlibdi, paccahı görübdü heylə, ürəyi partdıyır. Nağarsın? Bunu nətər danışmasın? Deyibdi: “Nənə, ay nənə. Məən ürəyim partdıyır ey. Mən öləjəm”. Cavan oğlan imiş. Qoyun güdürmüş. Gedə bilməyib qoyun-zad güdməyə də. Deyib: “Nolub ay oğul, səə. Dərdin nədi?” –nənəsi deyib. Deyibki, ay nənə, səə disəm, heş kimə diməzsən ki? Mənim bir dərdim var, ürəyimi partladır. Məə “Quran”a and veribdi paccah, ona görə də mən onu danışammaram. İxtiyarım yoxdu, səə də danışammaram. Deyib: Oğul, indi ki, məə dimirsən, getginən bir quyuya danışginən. Bir quyu qaz, ona danışginən. Danışannan sonra üstünü torpaxlaginən”. Heylə də eliyir. Gedir dağın döşündə quyu qazır. Quyuya deyir ki, neçəsini öldürübdü paccah. Mən getdim paccahın üzünü qırmağa. Paccahın buynuzları var. Zülqəreynənin buynuzu var. Eşşək qulaxları kimi də qulaxları var imiş. Eşşək qulaxları var. Danışıb, üstünü də torpaxlıyib. Möhkəm torpaxlıyib da burdan səs çıxmaz. Çıxıb gəlib, arxayın olub da. Paccah hər gedəndə buna xələt verib, o yan-bu yan, qızıl-gümüş verib da. Yaxşı oldu ki, danışmadı mənim sirrimi. Bir günnəri başqa bir çoban – bu, daa heş çobannıx eləmir – qoyun güdürmüş dağda. Görüb ki, yaxşı bir qarğıdımı, gamışdımı var. Başdıyır, deyir, bunnan yontalıyib tütək qayımağa. Çaldıxca görür ki, İsfəhan paccahının eşşək qulaxları var, Zülqəreynənin eşşək qulaxları var, buynuzu var, tütək elə bil oxuyur. Heylə danışır. Vay, bütöv yayılır səs hər yerə ki, tütəkdə bir şey diyillər. O nə sözdü? Çağırtdırır həmənlə dəlləyi yanına. Deyir: “Gedin tütək çalan çobanı bəri çağırın”. Çağırılar çobanı. Deyir ki, səə bunu kim deyib, kim danışdı? Deyir: “Paccah sağ olsun...”. Demək, başını-zadını bürüyür, heç боллоу гəşарасı görünмүр, бирсə сифəти, үзүнə də şey салıрмıш, сифəтини гөстəрмirmıш. Pərdənin далında danışırмıш. “Quran”a and içəjəhsən ki, гөрək səə kim deyibdi. Deyib: “Paccax sağ olsun, “Quran”a and iç deyirsən, and içim. Boynumu vurdurursan, vur. Dağda qoyun güdürdüm, гөрдüm qarğı var orda. Qarğıdan kəsdim, tütək qayırdım, çaldım, belə oldu”. – “Bəs bu nətəri olub?” Deyib: “Paccah sağ olsun, ürəyim partdıyır, ölürdüm. Gedib mən onu dağın döşündə quyu qazıb quyuya danışmışdım ki, burdan səs çıxmaz, heş kim eşitməz. And içirəm, genə də and içirəm ki, şeş kimə danışmamışam”. O oğlan da deyir ki, mən onu görməmişəm, tanımıram da. Heş nə də dimiyib. Onnan sonra paccah deyib ki, doğrudan da, sirr batmır. Nolur olsun, sirr batmırmıш. Elin, camaatın ağzınнан уığмах олмурмуш. Paccah olmuyub nə olsan da, yenə sirr batmırmıш. Oları da azad eliyir, boynunu-zadını vurmur. Deyib: “Da gojalmışam. Kim nə bilirsə, bilsin”. (Рюстемзаде 2006: 263-264)

#### Исгендерийн эвэр

Нэг падишах байжээ. Тэр падишах эвэртэй ажээ. Гэхдээ падишахын эврийг хэн ч хараагүй билээ. Гэхдээ түний хажуугаар орж гарах түүний үйлчлэгч харжээ. Нэг үсчин байжээ. Тэр бас хажууд нь орж гарах найз нь харжээ. Зөвхөн нэг үг амнаас чинь сонсвол түүний дараа толгойг чинь авна гэж хэлдэг байжээ. Тэгээд толгойг нь авдаг байжээ. Аль нэг өдөр падишахын үсийг зассан үсчийн үхэх цаг нь ирдэг байжээ. Түүнээс хойш хичнээн үсч авчирсан ч үсийг нь тайрангуут миний нууц задрахгүй байг гэж толгойг нь авдаг байжээ. Юу ч болсон ярьцгаана гэж мэдэж байжээ. Эцэстээ газар дэлхийд үсч үлдсэнгүй. Зөвхөн нэг л ч үс тайраачин үлджээ. Одоо яах вэ? гэжээ Энэ үсчийг авчраад, толгойг нь авбал дахиад нэг ч үс тайраачин үлдэхгүй ажээ. Падишах:

-Түүнийг авчир түүнд даалгавар өгнө гэв. Үс тайраачин хоньчин ажээ. Ууланд хонь дагадаг байжээ. Тэр үсчийг авчрав. Тэрбээр эхлээд үсийг нь засчээ. Огтхон ч эмээсэнгүй.

-Чи энэ нууцыг нэг л ам алдвал чамайг газар ухаад газар доогуур орлоо ч толгойг чинь тасдана гэж падишах зарлиглажээ.

-Ойлголоо, хэнд ч хэлэхгүй гэжээ. Ирээд падишахыг харангуут зүрх нь хагарна. Тэр одоо яах вэ? Үүнийг дахин хэлэхгүй байна гэж?

-Ээж ээ, миний зүрх хагарах нь. Би үхлээ гэжээ. Залуу хүү ажээ. Хонь хариулдаг байжээ. Явж, хонь хариулж чадахаа больжээ. Ээж нь

-Юу болов хүү минь Юунд зовов? гэжээ.

-Ээж ээ, чамд хэлбэл чи хэнд ч битгий хэлээрэй гэв.

-Надад нэг зовлон байна. зүрх минь хагарах нь гэжээ. Падишах намайг Куран сударт андгайллуулсан. Тэгэхээр би хэнд ч хэлэхгүй гэв. Надад хэлэх эрх байхгүй чамд ч хэлэхгүй гэв.

-Хүү минь надад хэлэхгүй юм бол яваад нэг нүхэнд хэлээч. Нэг нүх ухаад нүхэнд хашгир. Хашгирсныхаа дараа нүхээ шороогоор бул гэжээ. Хүү яг ээжийнхээ хэлсний дагуу хийв. Яваад уулын энгэрт нүх ухаад,

-Падишах хичнээн их хүн үхүүлэв. Би падишахын үсийг тайрахаар очсон. Падишах эвэртэй юм билээ. Зюлкереин эвэртэй юм билээ. Илжигний чих шиг чихтэй юм билээ. Илжгэн чихтэй юм билээ гэж хэлээд нүхээ шороогоор булжээ. Эндээс дуу гарахгүй гээд бөх гэгч нь шороогоор булжээ. Явж ирээд тайвширчээ. Падишах энэ үс тайраачид очих бүрт нь бөс хувцас бэлэглэж, зүйл бүрээр алт мөнгө ч өгчээ. Миний нууцыг хэлээгүй нь сайхан гэв. Нэг өдөр өөр нэг хоньчин тэрээр огт хонь хариулж үзээгүй хэдий ч ууланд хонь дагаад явж байжээ. Сайхан хулс зэгс аль аль нь байгааг харав. Хулсыг огтлож гуурсан бишгүүр хийж эхлэв. Бишгүүрээ үлээж байтал Исфаганы падишах илжгэн чихтэй юм билээ. Зюлкереин илжгэн чихтэй юм билээ, эвэртэй юм билээ гэж бишгүүр дуугарав. Ийн ярив. Энэ үгс бүхэлдээ цуурайтан тархав. Бишгүүрийн дуу биш. Ямар үг вэ?

Үсчийг тэр даруй дууджээ. Яваад гуурсан бишгүүр үлээх хоньчныг дууд гэв. Хоньчныг дууджээ.

-Чамд үүнийг хэн хэлж, хэн ярьсан бэ? гэжээ.

-Падишах минь өршөөж ажаам уу. Падишах толгойгоо бүтээж, юу ч харагдахгүйгээр битүү хувцаслаж, хацраа далдалж нүүрээ харуулдаггүй байжээ. Хөшигний араар ярьдаг байжээ.

-Чи Куран сударт андгайл. Хэн чамд хэлсэн бэ хэл.

-Падишах өршөөж ажаам уу. Куран сударт тангарагла гэвэл тангараглая. Толгойг минь авбал ав ууланд хонь хариулаад явж байхад хулс мод харсан юм тэр хулсаар гуурсан бишгүүр хийж үлээсэн ердөө л энэ.

-Энэ л гэж үү?

-Падишах өршөөж ажаам уу Зүрх минь хагарч үхэх гэж байв. Би яваад уулын энгэрт нүх ухаад нүхэнд хашгирсан тэндээс дуу гэдагшлахгүй, хэн ч сонсохгүй. Андгайल्या би дахин андгайल्या би хэнд ч би хэлээгүй гэжээ. Нөгөө хүү ч би түүнийг хараагүй таних ч үгүй гэжээ. Дараа нь падишах:

-Үнэндээ нууц нууцаараа үлдэхгүй. Юу ч боллоо гээд нууц нууцаараа үлддэггүй юм байна. Ард олны амыг хорьж болдоггүй юм байна. Падишах биш хэн ч байсан нууц нууцаараа үлддэггүй юм байна. гэжээ Падишах тэднийг өршөөж толгойг нь авсангүй.

-За би өтөлжээ. Үүнээс хойш хэн ч гэлээ мэдвэл мэдэг хэмээжээ.

Македонийн Александр буюу Искандер хааныг эвэртэй эсвэл илжигний чих мэт урт чихтэй гэх өгүүлэмж түрэг ард түмнүүдийн “Искандернаме” нэртэй зохиолууд болон аман зохиолд буй. Ялангуяа азербайжан түрэгийн уран зохиолын хүрээнд перс хэлээр бүтээлээ туурвиж асан түрэгийн яруу найрагч Низами Гянжевигийн

(Жемаль ад-Дин Абу Мухаммад Ильяс ибн Юсуф ибн Закки буюу Низами Гянджеви, персээр *نیزامی گنج‌نما* *Nizāmī Ganjavī*, 1141-1209) нөлөөгөөр Искандерийн сэдэв ихэд дэлгэрчээ. Низамигийн “Искандернаме” хэмээх найраглалын “Икбалнаме” гэх хэсэгт Македонийн Александр буюу Искандер хааны Зюлкарнейн (Зюлкарнейн араб үг юм. арабаар *ذُو نَيْرِ كَرْنَيْن*, *Dū l-Qarnayn* хос эвэрт *Zū'l-karneyn* гэнэ. Арабаар *zū* нь эзэн гэх утгатай үг ба *(e)l* нь ялгац үг, *karneyn* нь *karn* буюу эвэр гэх үгийн тесниез буюу хоёр эвэр гэх үг болно. Зюлкарнейн гэх үг Исламын шашны ариун эх Куран судрын (арабаар *أَلْقُرْآن* *al-Qur'ān* уншилга гэх утгатай араб үг) Кехф Сурад гарах хүний нэр аж.) гэх хоч нэршилтэй холбон Искандер хааны урт чихний тухай шүлэглэснээс хураангуйлбал, “Искандер падишах урт чихтэй байжээ. Искандер чихээ нууж малгай өмсдөг ба боол үсчин нь үхсэн тул шинэ үсчнээр үсээ засуулаад нууцыг чандлан хадгалахыг шаардаж нууцыг задалбал цаазаар авна гэв. Үсчин нууцыг хэнд ч хэлдэггүй. Гэвчиг үүнээс болоод зовлонд автаж гэдэс нь хөөж, тайвшрахын тулд цөл газар лүү явна. Цөлд харагдах нэг худаг руу ойртон очоод “Шахын чих их урт” гэж хэлнэ. Ингээд тайвширч гэр лүүгээ буцна. Хэсэг хугацааны дараа тэр худгаас хулс ургана. Нэг хоньчин уг хулсыг огтолж хулсаар бишгүүр хийнэ. Хоньчин бишгүүрээ үлээхтэй цуг бишгүүр нууцыг задлана. Нэг өдөр Искандер цөлөөр явж байтал, нэг хоньчны амандаа зуусан бишгүүр “Шахын чих урт” гэж хашгирахыг сонсоно. Шах хоньчинг дуудаад яагаад ингэсний учрыг асууна. Хоньчин худганд ургасан хулсыг тайрч бишгүүр хийсэн бишгүүр дотроос нэгэн чимээ гарсан, өөр юу ч мэдэхгүй гэнэ. Искандер ордон луугаа буцаж очингуутаа үсчнээ дуудна. Хэрвээ илдээр тас цавчуулахгүйг бодож байгаа бол үнэнийг хэл гэнэ. Үсчин ам тангаргаа тавиад юу болсныг ярина. Искандер үсчнийг үнэн хэлсэн эсэхийг ойлгохын тулд худагт ургасан хулсны мөчрөөр дахин бишгүүр хийлгэнэ. Шинээр хийсэн бишгүүрээс адил үг хэл гарахыг сонсоод Искандер падишах энэ дэлхийд юу ч нууцаараа үлдэж болдоггүйг ухаарч үсчнээ өршөөнө “(Низами 2004: 41-44) гэж гарна.

Бидний авч үзэж буй монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэр, түүнчлэн азербайжаны “Искандерын эвэр” гэх үлгэрийн өгүүлэмж эртний грект “Мидасын чих” гэх нэрээр түгсэн билээ. Эртний Грекийн “Илжгэн чих” буюу “Мидасын чих” гэх үлгэрийн өгүүлэмж Н.П. Андреевийн “Аарнегийн тогтолцооны үлгэрийн өгүүлэмжийн товъёог”-т 716 дугаарт бүртгэгджээ. Н.П. Андреев энэхүү өгүүлэмжийг “Хаан илжгэн чихтэй байна, Үсчин үүнийг мэднэ гэвч үхэх аюултай учир энэ нууцыг хадгалах ёстой. Үсчин энэ тухай газарт усанд ярина, ургаж байгаа мод хулс нууцыг задлана” гэж товч тоочжээ.

Эртний ромын яруу найрагч Овидийн “Хувирлууд” (Метаморфозия латинаар *Metamorphoses*, Овидий буюу Публий Овидий Назоон. латинаар *Publius Ovidius Naso* МЭӨ 43-МЭ 18) гэх найраглалд л бүрэн агуулгаараа гардаг (Костюхин 1972: 57) эртний грекийн энэ домогт Пан тэнгэр гуурсан бишгүүр үлээж чаддагаараа бахаддаг байжээ. Пан нэг удаа Аполлон тэнгэрийг уралдаан наадаанд дууджээ. Наадан өрсөөн Тмол уулын энгэрт болсон ба энэ уулын эзэн шүүгч нь байв. Улбар өмсгөл өмсөж, алтан ятга барьж лаврын титэм зүүсэн Аполлон иржээ. Пан тэнгэр эхлэн бишгүүрээ үлээв. Малчны бишгүүрийн энгийн аялгуу Тмол уулын энгэр бэлээр зөөлнөөр дэгдэж, Пан бишгүүрээ үлээж дуусав. Паны бишгүүрийн дуу намжихад Аполлон тэнгэр ятын алтан чавхдсаа татав. Тэнгэрлэг хөгжмийн агуу эгшиг хөвсөлзөв. Эргэн тойрон тэр чигтээ уяран хайлан хөгжмийг сонсож байв. Ятгын алтан чавхдас цог жавхлантайяа түрэн байгаль дэлхий тэр чигээрээ нам гүмд автан, нам гүм дунд гайхамшигт сайхан аялгуу давалгаалан жингэнэнэ. Аполлон зогсож, түүний ятгын сүүлчийн хөг эгшиглэв. Тмол уулын эзэн Аполлонд

ялалтыг оноов. Цугласан бүх хүн ард ятгачин тэнгэрийг магтаж байв. Зөвхөн Мидас ганцаараа Аполлоны авьяас билигт баяссангүй. Пан тэнгэрийн энгүүн аяыг магтжээ. Аполлон тэнгэр хилэгнэж Мидасын чихнээс угзраад сунгачихжээ. Тэр цагаас хойш Мидас илжгэн чихээ том нөмрөгт нууж явах болжээ (Кун 1954: 83)

Фригийн хаан Мидас Аполлон тэнгэр Пан тэнгэрийн хоорондын хөгжмийн тэмцээн наадмыг шүүж (энэ сэдэл басхүү Аполлон Тэнгэр Марсий тэнгэр хоёр хооронд тэмцээн наадгай болсон гэж өөрөөр бас байдаг. (М. У.) (Ботвинник, Коган, Рабинович, Селецкий 1961:143) улмаар Аполлоныг ялсан гэж зөвшөөрнө. Өөр хувилбараар бол Аполлон тэнгэр Пан тэнгэрийн хооронд болсон энэ уралдаан наадааныг Лидийн Тмол тэнгэр шүүж Аполлоныг түрүүлсэн гэж тооцох ба харин Мидас хаан Тмол тэнгэрийн энэ шийдвэрийг эс зөвшөөрч Марсийг түрүүлсэн гэдэг аж. Үүнээс болж Аполлон тэнгэр Мидас хааныг илжигний чихээр мялаасан ба Мидас илжгэн чихээ Фригийн малгайдаа нууж явах болжээ. Мидасын үсийг тайраачин хааныхаа чихийг хараад хэнд ч хэлэхгүй байна гэхээс зовж шаналаад газарт нүх ухаад ухсан нүхэндээ Мидас хаан урт чихтэй юм билээ гэж шивнээд нүхийг булна. Гэтэл тэр газар зэгс ургаж энэ нууцыг бүх дэлхийд тархаана (Ботвинник, Коган, Рабинович, Селецкий 1961:143)

Аполлон тэнгэр Фригийн хааныг илжгэн чихтэй болгодог. Мидас гэмт үйлээсээ бус тэнэг авираасаа болж энэхүү шийтгэлийг амсчээ. Аполлон Пан хоёрын хөгжмийн тэмцээн наадаанд Мидас шүүгчээр тохоогджээ. Талын эзэн Пан бишгүүрээрээ аятайхан дуу эгшиглүүлж байсан ч Аполлоны мөнгөн лир ятга бүхий л хөгжмийн зэмсгээс илүү гайхамшигтай байв. Аполлон хөгжмөө татав уу үгүй юу Муза охин тэнгэр нэр ч хүртэл амсхийж түүнийг сонсдог байв. Өөр нэг шүүгч болох хээр талын эзэн Тмолос Аполлоныг ялсанд тооцов. Гэвч гайхамшигт хөгжмийг үл ухах Мидас Паныг ялсан гэжээ. Аполлон түүнд уурлаж Мидасыг илжгэн чихтэй болгов. Мидас энэхүү тэнгэрийн бэлгийг элбэгжүү малгайнд нуужээ. Түүний үсийг авсан үсчин чихийг нь хараад чихийг нь харсан гэж хэнд ч хэлэхгүй гэж ам өчиг өгөв. Үс тайраач тэсэлгүй нүх ухаад хулс зэгсийн дундуур ороод “Мидас хааны чих” гэж шивнэв. Хэсэг хугацаа өнгөрөв. Нүхийг тойрон ургах зэс хулс салхи үлээнгүүт “Хаан Мидасын чих, илжгэн чих” гэж хашгирч эхэлжээ. Ийнхүү хүн бүр үнэнийг мэджээ. (Козаноглу 1992: 124-125)

Мидас Панын бишгүүрийг Аполлоны ятгаас илүүд үзсэн тул Аполлон түүнийг илжгэн чихтэй болгожээ. Чихнээсээ туйлгүй ихээр ичих болсон Мидас чихээ хичээнгүйлэн нууж эхэлсэн ба нэг өдөр түүний үсийг тайраач илжгэн чихийг нь яаж ийгээд харчихаж гэнэ. Мидас түүний нууцыг сайх үс тайраач мэдсэнийг ойлгоод түүнийг дуудан энэхүү нууцыг хаа нэгтээ хэлбэл хөнөөнө гэж эрс чангаар сануулжээ. Хөөрхий үс тайраачин хааны нууцыг удаан хугацаанд хадгалсан ч чалчаа үсчин энэ нууцыг хаа нэгтээ хэлэхгүй бол тэсэхгүйгээ ухаараад, аглаг хөдөө газар нүх ухаж “Мидас хаан илжгэн чихтэй” гэж хоолойныхоо чадлаар хашгираад нүхийг булжээ. Нүхийг булсан хэдий ч тэр булсан газраас мянга мянган зэгс хулс ургаж салхины аясаар найган ганхаж бие биеэ шүргэлцэхийн хирээр “Мидас хаан илжгэн чихтэй” гэж дуу авиа гаргаж эхэлцгээжээ. Ийнхүү хааны нууцыг хүн бүр сонссоноос болж хөөрхий Мидас бухын цус уугаад амиа егүүтгэжээ. (Козаноглу 1992: 275-276)

Энэ мэтчилэн Илжгэн чихт хааны үлгэр дэлхийн олон үндэстний аман зохиолд тарсан бөгөөд Р. Чүлтэмсүрэн солонгосын “Кён Мун хааны малгай” гэх үлгэрийг монгол “Илжгэн чихт хаан” үлгэрийн нэг хувилбар гэж үзжээ. (Чүлтэмсүрэн 2011:64) Чой Инхакын “Солонгос ардын үлгэрийн хэв маягийн товъёог”-г энэ өгүүлэмж Хааны чих бол илжигний чих гэсэн нэрээр 758 дугаарт бүртгэгджээ.

(Чой Инхак 1979: 329) А. Ф. Троцевич Солонгос “Илжгэн чихт хаан”-ы үлгэрийн өгүүлэмжээс харахад Мидасын түүх Хойд Энэтхэг, Төвд, Монголыг дамжин дорнод Азид хүрч ирэв. Гэхдээ энэ үлгэр дорно тийш нүүхдээ шинэ мотивууд сэдлүүдийг үүсгэсэн гэжээ. (Троцевич 1995: 286).

Монгол тува үлгэр азербайжан Искандерийн эвэр гэх үлгэр өөр хоорондоо ялгарсан байвч энэхүү өгүүлэмжийн бусад үндэстний үлгэртэй адилсдаг бүтцийн үндсээ хадгалж чаджээ. Өөрөөр хэлбэл монгол, тува “Илжгэн чихт хаан”, “Элчиген Кулак Хаан” зэрэг үлгэрүүд, мөн Азербайжаны “Искандерийн эвэр” гэх үлгэрүүд өгүүлэмжийн хэв маягийн хувьд үндсэндээ ижил юм. Профессор С. Дулам бидний дээр сурвалж эх болгон сонгон аваад тува эхүүдтэй харьцуулсан монгол “Илжгэн чихт хаан” үлгэрийн төв халхын хувилбарыг “Мидас хааны чих” гэх грек домогтой харьцуулаад ялангуяа төгсгөл хэсэг эл хоёр үлгэрт нарийн ширийн дүр дүрслэлээр хүртэл таарч тохирч байдаг гэж бичсэн билээ. (Дулам 2018:548)

### Дүгнэлт

Монгол “Илжгэн чихт хаан” үлгэрийг тува “Элчиген-Кулак Хаан” гэх үлгэр лүгээ бас азербайжаны “Искандерийн эвэр” гэх үлгэртэй харьцуулж мөн монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэрийг төвөд, монгол “Шидэт хүүрийн үлгэр”-тэй харьцуулж үзэхэд, монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэрүүд энэхүү “Шидэт хүүрийн үлгэр” гэх хажилгат туужийн айн хүүрнэл цоморлиг монгол тува аман зохиолд үлгэр болон дэлгэрсний баримт болж байна. Тува аман зохиолд монголын уран зохиолын хажилгат туужийн айн дурсгалуудаас зээлэгдсэн өгүүлэмж өргөн тархсан ба тува аман зохиолд Шидэт хүүрийн үлгэрийн өгүүлэмж бүхий олон аман үлгэр бий. Үүнийг нэг нь “Элчиген-Кулак хаан” буюу “Илжгэн чихт хаан” гэх үлгэр юм. Монгол тува “Илжгэн чихт хаан” үлгэр, түүнчлэн азербайжаны “Искандерын эвэр” гэх үлгэрийн өгүүлэмж эртний грект “Мидасын чих” гэх нэрээр түгсэн билээ. Монгол тува үлгэр азербайжан “Искандерийн эвэр” гэх үлгэр өөр хоорондоо ялгарсан байвч энэхүү өгүүлэмжийн бусад үндэстний үлгэртэй адилсдаг бүтцийн үндсээ хадгалж чаджээ. Өөрөөр хэлбэл монгол, тува “Илжгэн чихт хаан”, “Элчиген Кулак Хаан” зэрэг үлгэрүүд, мөн Азербайжаны “Искандерийн эвэр” гэх үлгэрүүд өгүүлэмжийн хэв маягийн хувьд үндсэндээ ижил юм.

### Ном зүй

- Андреев Н. П. Указатель сказочных сюжетов по системе Аарне. Государственное русское географическое общество. Ленинград, 1929.
- Борлыкова Б.Х. “О международном сказочном сюжете “Ослиные уши” (Уши Мидаса)”, Современные проблемы науки и образования 2015 № 1-2. Москва, 2015.
- Ботвинник М. Н., Коган М. А., Рабинович М. Б., Селецкий Б. П. Мифологический словарь Ленинград, 1961
- Владимирцов Б. Я. “Монгольская литература”, Б. Я. Владимирцов Работы по литературе монгольских народов Москва: Издательская фирма “Восточная литература” Российской Академии Наук, 2003.
- Волшебный мертвец. Монгольско-ойратские сказки. Перевод Б. Я. Владимирцова. Издательство восточной литературы Москва, 1958.
- Донгак А. С. Сюжеты и мотивы “обрамленных повестей” в тувинской сказочной традиции. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата филологических наук. Улан-Удэ, 2004.
- Дамдинсүрэн Ц., Серебряный С. Д. “Обрамленные повести в Индии и у монгольских народов. Некоторые проблемы и перспективы исследований”, Ц. Дамдинсүрэн Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудалд Улаанбаатар, 1987.

- Дамдинсүрэн Ц, Төвд, Монгол шидэт хүүрийн үлгэр нэг хоёрдугаар дэвтэр, Цэндийн Дамдинсүрэн Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. III боть. Улаанбаатар, 2017.
- Дулам. С “Монгол герегийн домгийн зарим дүр өгүүлэмжийг харьцуулсан нь”, Сэндэнжавын Дулам Монгол аман зохиол харьцуулсан аман зохиолын судалгаа. Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган II боть. Улаанбаатар, 2018.
- Костюхин Е.А. Александр Македонский в литературной и фольклорной традиции. Москва, 1972.
- Кун Н. А. Легенды и мифы древней Греции. Москва, 1954
- Манджиева Б. Б. “Кумулятивная сказка у калмыков (синоптический анализ contemporaneous текстов)”, Научная мысль Кавказа. № 1(65). Ч. 2. 2011
- Мигир-Мижит хаан Тургускан А.С. Донгак, Б. Баярсайхан, О.М. Саая Кызыл, 2020.
- Мэргэн ардын үг Эрх чөлөөни сэдэвтэй ардын аман зохиол Эмхэтгэн боловсруулж, удиртгал, тайлбар бичсэн Ч. Жачин Улаанбаатар, 1988
- Троцевич А. Ф. “Сюжет “царь с ослиными ушами” в корейской литературе. К изучению проблемы взаимодействия культур Востока и Запада”, Петербургское востоковедение, выпуск 7, Центр “Петербургское Востоковедение” Санкт-Петербург, 1995.
- Чүлтэмсүрэн Р. ““Илжгэн чихт хаан” үлгэрийн өгүүлэмж, хэв шинжийн онцлог”, Р. Чүлтэмсүрэн Монгол аман билиг. Улаанбаатар, 2011.
- Choi In-Hak A Type Index of Korean Folktales. Seoul: Myongi University, 1979.
- Kozanoğlu T., Yunan mitolojisi Ankara: Hera Yayıncılık 1992
- Nizami Gəncəvi İskəndərnamə. İqbalnamə. Bakı: Lider Neşriyyat, 2004.
- Rüstəmzadə İ., Azərbaycan Folkloru Antologiyası XVI. kitab Ağdaş Folkloru, Bakı: Səda neşriyyat, 2006.

### **Ашигласан эх хэрэглэгдэхүүн**

- Илжгэн чихт- Мэргэн ардын үг. Эрх чөлөөний сэдэвтэй ардын аман зохиол. Эмхэтгэн боловсруулж, удиртгал, тайлбар бичсэн Ч. Жачин Улаанбаатар 1988: 153-155
- Илжгэн чихт хаан - С. Дулам Монгол, герег домгийн зарим дүр, өгүүлэмжийг харьцуулсан нь Сэндэнжавын Дулам Монгол аман зохиол харьцуулсан аман зохиолын судалгаа. Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган II боть Улаанбаатар 2018: 547
- Элчиген-Кулак хаан- Архив Тувинского института гуманитарных и прикладных социально-экономических исследований том 9, дело 39: 8-14
- Элчиген-Кулак хаан- Мигир-Мижит хаан, Тургускан: А.С. Донгак, Б. Баярсайхан, О.М. Саая. Кызыл, 2020:157
- Шидэт хүүрийн үлгэрийн Илжгэн чихт хааны бүлэг- Дамдинсүрэн Ц, Төвд, Монгол шидэт хүүрийн үлгэр нэг хоёрдугаар дэвтэр, Цэндийн Дамдинсүрэн Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган III боть Улаанбаатар 2017
- Isgəndərin buynuzu- İ. Rüstəmzadə Azərbaycan Folkloru Antologiyası. XVI kitab Ağdaş Folkloru, Bakı: Səda neşriyyat. 2006: 263-264

### **Summary**

This paper presents a comparative analysis of the descriptions of the Mongolian Tuvinian fairy tales Илжгэн чихт хаан Элчиген Кулак Хаан “King with donkey ears”. This fairy tale is widely circulated, there is a fabulous traditions of Mongolian and Tuvinian peoples. We also have compared the Mongolian and Tuvinian fairy tales Илжгэн чихт хаан Элчиген Кулак Хаан “King with donkey ears” with Azerbaijani Isgəndərin buynuzu “Horns of Iskander”. As for us, these fairy tales in Mongolian and Turkish fabulous tradition has undergone a certain transformation, but the plot kept general international structural basis, which is natural for the world of folklore.